

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. <i>Төслийн ерөнхий мэдээлэл</i>	3
1.2. <i>Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа</i> 5	
1.3. <i>Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт</i>	7
1.3. <i>Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим</i>	8
1.4. <i>Үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц</i>	8
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	11
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	12
3.1 <i>Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж</i>	12
3.2 <i>Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим</i>	12
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	16
4.1. <i>Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</i>	17
4.2. <i>Үйлдвэрийн орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө</i>	19
4.3. <i>Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө</i>	19
4.4. <i>Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	20
4.5. <i>Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</i>	20
4.6. <i>Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал</i>	21
4.7. <i>Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр</i>	22
4.8. <i>Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө</i>	24
4.9. <i>Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь</i>	24

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Бутлах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт	7
Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим	8
Хүснэгт 3. Үйлдвэрт хэрэглэгдэх усны хэрэгцээ.....	9
Хүснэгт 4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	12
Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	14
Хүснэгт 6. Гол сөрөг нөлөөлөл.....	15
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....	17
Хүснэгт 8. Ногоон байгууламжийн төлөвлөгөө	19
Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	22
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 15. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь	24

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем.....	6
Зураг 3. ОХШХ-ийн дээш авах цэгүүд.....	23

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр” төсөл																	
Төсөл хэрэгжүүлэгч:	“ШАШИР-ОРГИЛ” ХХК. Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Элчингийн гудамж, 9 скай плаза. Утас: 8888-5368																	
Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:	Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн хойшоо 440 км, Хэнтий аймгийн Батноров сумын төвөөс хойш 11 км, Норовлин сум явах замын хойд талд байрлана. Талбайн солбицлууд: <table><tr><td>1.</td><td>48° 02' 01.98”</td><td>111° 26' 33.78”</td></tr><tr><td>2.</td><td>48° 02' 18.50”</td><td>111° 26' 33.78”</td></tr><tr><td>3.</td><td>48° 02' 18.39”</td><td>111° 26' 53.29”</td></tr><tr><td>4.</td><td>48° 02' 01.97”</td><td>111° 26' 53.29”</td></tr></table>			1.	48° 02' 01.98”	111° 26' 33.78”	2.	48° 02' 18.50”	111° 26' 33.78”	3.	48° 02' 18.39”	111° 26' 53.29”	4.	48° 02' 01.97”	111° 26' 53.29”			
1.	48° 02' 01.98”	111° 26' 33.78”																
2.	48° 02' 18.50”	111° 26' 33.78”																
3.	48° 02' 18.39”	111° 26' 53.29”																
4.	48° 02' 01.97”	111° 26' 53.29”																
Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:	Улсын бүртгэлийн гэрчилгээ <table><tr><td>✓</td><td>Улсын бүртгэлийн дугаар:</td><td>9019016141</td></tr><tr><td>✓</td><td>Регистрийн дугаар:</td><td>2812231</td></tr><tr><td>✓</td><td>Улсад бүртгүүлсэн:</td><td>2006.12.25</td></tr></table> Газрын гэрчилгээ <table><tr><td>✓</td><td>Дугаар:</td><td>Э-1814000076</td></tr><tr><td>✓</td><td>Олгосон огноо:</td><td>2020.02.13</td></tr></table>			✓	Улсын бүртгэлийн дугаар:	9019016141	✓	Регистрийн дугаар:	2812231	✓	Улсад бүртгүүлсэн:	2006.12.25	✓	Дугаар:	Э-1814000076	✓	Олгосон огноо:	2020.02.13
✓	Улсын бүртгэлийн дугаар:	9019016141																
✓	Регистрийн дугаар:	2812231																
✓	Улсад бүртгүүлсэн:	2006.12.25																
✓	Дугаар:	Э-1814000076																
✓	Олгосон огноо:	2020.02.13																



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2.Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

1.2.1. Хайлуур жоншийг баяжуулах технологийн сонголт

Технологийн туршилтаас дүгнэхэд технологийн үзүүлэлтүүд болон санал болгож буй схемүүд нь ижилхэн байгаа тул зөвлөмжийн дагуу 2 шатны бутлалттай, 1 шатны нунтаглалттай, ангилалтаас үндсэн флотаци 1 болон 6 цэвэрлэгээний флотацитай, 2 хяналтын флотацитай технологийн схемийг сонгосон.

Жоншны хүдрийг баяжуулах технологи

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн схемийг сонгохдоо баяжигдах шинж чанарын туршилтын үр дүн, үйлдвэрлэлийн хүчин чадал, баяжмалын чанар зэргийг харгалзан үзэхэд флотацын аргаар баяжуулахад чанарын шаардлага хангасан эцсийн бүтээгдэхүүн болох ФФ97 маркийн жоншны баяжмал гарган авах боломжтой нь технологийн туршилтаар батлагдсан.


Бутлах хэсэг нь хүдрийн шинж чанар хатуулаг, сулралын зэрэг баяжуулалтын үр дүн зэргээс хамааруулан III-шатны бутлалт болон нэг шатны нунтаглалтад орох ба анхан шатны том бутлалтад PE500*750 маркийн хацарт бутлуур -100мм ширхэглэлтэй болтол бутлан дунд шатны бутлалтад PE150*750 маркийн хацарт бутлуураар бутлагдан -20мм ширхэглэлтэй болтол бутлагдан доргиур шигшүүрээр шигшигдэн шигшүүрийн дээрх бүтээгдэхүүн конусан бутлуурт орж -3мм-ийн ширхэглэлтэй болон бутлагдана.

Бутлагдсан нунтаг хүдэр нь нунтаглалтад GMG2436 маркийн бөмбөлөгт тээрэмд орж нунтаглагдан нунтаглалтаас гарсан бүтээгдэхүүн нь мушгиа ангилагч (FLG2000)-д орж ангилагдан том ширхэглэлтэй бүтээгдэхүүн нь буцаж нунтаглалтад орж нарийн ширхэглэлтэй хүдэр нь флотацын тэжээлийн холигч чаннруу орж анхан шатны флотацид өгөгдөнө.

Үндсэн флотацын баяжмалыг 6 шатны цэвэрлэгээний флотацаар оруулж 97%-ийн агуулгатай жоншны баяжмал гарган авах ба баяжмалыг өтгөрүүлэгчид өтгөрүүлэн хатуулгын агуулга 55%-тай болтол өтгөрүүлж, вакум филтрээр 10%-ийн чийглэгтэй болтол нь усгүйжүүлнэ.

Үндсэн флотацын хаягдлыг нь 2 шатны хяналтын флотацид оруулах ба анхан шатны хяналтын флотацын баяжмал бүтээгдэхүүн нь үндсэн флотацид битүү циклээр дахин тэжээгдэнэ.

Хяналтын хоёр дахь шатны флотацын баяжмал нь хяналтын флотаци-I-д ачаалагдах ба хаягдлыг нь шүүн шахах хэсгийн пресс филтрээр усгүйжүүлэн хаягдлын овоолгод хаяна.



Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем

1.3.Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт

1.5.1 Бутлах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголт, тооцоо

Уурхайгаас олборлосон жоншны тодорхой хэсгийг лазер төхөөрөмжөөр баяжуулах бөгөөд үлдсэн хэсгийг баяжуулах үйлдвэрийн талбай руу автосамосвалаар тээвэрлэн хүргэнэ. Уурхайгаас ирсэн өөр өөр агуулгатай хүдрийг тус тусад хүдэр хүлээн авах талбайд овоолго үүсгэн хуримтлуулах бөгөөд үйлдвэрт тэжээхийн өмнө чанарын дундажлалтыг хийнэ. Анхан шатны хүдэр хүлээн авах бункер нь 50м³-ын багтаамжтай.

Бункерийн доор байрлах CG980*1240 маркийн тэжээгүүрээр хүдрийг анхдагч хацарт бутлуурт өгнө. Хацарт бутлуур (PE500*750)-ын тэжээх амсрын хэмжээ нь 500мм х750мм–хэмжээтэй ба тэжээх хүдрийн хамгийн том ширхэглэл нь 500мм байх бөгөөд 55кВт–ын хөдөлгүүртэй, цагт 34-68 м³/ц хүртэл бутлах суурилагдсан хүчин чадалтай юм.

Бутласан хүдрийг тэжээгч (CG980*1240)-ээр туузан дамжуулагч (TD-65)-т өгөх ба дамжуулагч нь цааш 23м зайд зөөвөрлөн Дунд шатны хацарт бутлуур (PE150*750)-т тэжээнэ. Хацарт бутлуурын хүлээн авах амсрын хэмжээ нь 150*750мм байх ба тэжээх хүдрийн хамгийн том ширхэглэл нь 180 мм байх бөгөөд 30кВт–ын хөдөлгүүртэй, цагт 10-32 м³/ц хүртэл бутлах суурилагдсан хүчин чадалтай.

Дунд шатны бутлуурт бутлагдсан хүдэр нь (TD65) маркийн дамжуулагчаар зөөвөрлөгдөн доргиурт шигшүүр (SZ1250)-ээр шигшигдэн шигшүүрийн доорх бүтээгдэхүүн нь нунтаглалтад орж, дээрх бүтээгдэхүүн нь конусан бутлуур (PVV100)-т дахин гүйцээн бутлагдаж нунтаглалтад орно.

Баяжуулах үйлдвэрийн бутлан бэлтгэх хэсгийн тоног төхөөрөмжийн бүтээмж харьцангуй өндөр ба үйлдвэрийн хоногийн бүтээлийг богино хугацаанд бэлтгэн нийлүүлэх боломжтой байна. Иймээс үйлдвэрийн өртөг зардлыг тооцож үзэн бутлах хэсэг нэг ээлжээр шөнийн цагаар ажиллах ба өдрийн ээлжийн бүтээлийг дундын агуулахад хуримтлуулна.

Хүснэгт 1. Бутлах хэсгийн үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Тоо, ширхэг	Хөдөлгүүр, кВт
1	Тэжээгүүр	CG980*1240	1	7.5
2	Хацарт бутлуур	ZG-PE500*750	1	45
3	Хоёрдогч бутлуур	ZG-PE150*750	2	15*2
4	Конусан бутлуур	PYY100	1	90
5	Доргиурт шигшүүр	1250*2500	1	15
6	Цахилгаан соронзон төмөр ангижруулагч	RCDB-650	1	1.6
7	Тоос цуглуулагч	DMC-150	2	5.5
8	Дамжуулагч	TD75-6550	2	15
9	Дамжуулагч	TD75-6550	1	11
10	Дамжуулагч	TD75-6550	1	11
11	Цахилгаан дан нуруутай кран	5T	1	9.9
12	Бусад		1	20.5
	Нийт			232

1.3. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим

Баяжуулах үйлдвэр нь тасралтгүй ажиллагаатай байх ба Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаараас саатах, ээлжит засвар үйлчилгээ, зэрэг хүчин зүйлүүдийг тооцон үйлдвэр нь 270 хоног ажиллана.

Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

1	Жилийн хуанлийн өдрийн тоо	365
2	Жилийн хуанлийн сар	12
3	Жилийн хуанлийн цаг	8760
4	Өдрийн хуанлийн цаг	24
5	Баяжуулах үйлдвэрийн ажиллах хоног	360
6	Төлөвлөгөөт засварын хоног	22
7	Урсгал засварын хоног	24
8	Баяр ёслолын хоног	11
9	Цаг агаарын саатал	8
10	Өвлийн улирлын сул зогсолтын хоног	30
11	Жилд ажиллах бодит хоног	270
12	Жилд ажиллах цаг	6480
13	Цаг ашиглалтын коэффициент, %	90
14	Жилд ажиллах бодит цаг	5832
15	Цагийн хүчин чадал, тн/цаг	25.72
16	Хоногийн хүчин чадал, тн/хоног	555.55
17	Жилийн хүчин чадал, тн/жил	150000

Баяжуулах хэсгийн ажиллах хүчний тооцоо

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд нийт 120 ажлын байр шинээр бий болно. Үйлдвэр хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Үйлдвэрийн ажилчид 20 хоног ажиллаж 10 хоног амрах ба удирдах албан тушаалтнууд болон санхүүгийн хэлтсийн ажилчдаас бусад нь ээлжийн амралтын системээр ажиллаж амарна. Баяжуулах үйлдвэрт нэг дор 82 ажилтан ажиллаж амьдрах ба 38 ажилтан ээлжийн амралт эдэлнэ.

1.4. Үйлдвэрийн барилга байгууламж, дэд бүтэц**1.4.1. Үйлдвэрийн усан хангамж**

Баяжуулах үйлдвэрийн технологийн болон ажилчдын ахуйн хэрэглээний усыг худгаас хангах бөгөөд үйлдвэрийн технологид шаардлагатай усыг баяжуулах үйлдвэрийн дэргэд байгуулагдах технологийн цэвэр усны санд хуримтлуулан тэндээс үйлдвэрийн хэрэгцээний усыг насосын тусламжтай үйлдвэрт тэжээнэ. Худгийн гүн нь 150 метр ба худгийн усыг ЭЦВ-6/16/140 маркийн насосоор шавхалт хийж үзэхэд ундарга нь 8л/с тогтоогдсон. Унд ахуйн хэрэглээний усыг худгаас хангана. Төслийн хүрээнд нийт 120 хүн ажиллах ба 2 ээлжээр ажиллана. Иймд үйлдвэрийн кемп дээр нийт 82 хүн байрлан ажиллахаар байна.

Хүснэгт 3. Үйлдвэрт хэрэглэгдэх усны хэрэгцээ

№	Үзүүлэлт	Хоногийн усны хэрэглээ, м ³	Жилийн усны хэрэглээ, м ³	Усны эх үүсвэр, ундарга	1 м ³ усны суурь үнэ, төгрөг	Жилийн зардал, мян.төг
1	Унд, ахуйн хэрэглээний ус, хоногт 80 л/хүн	6.56	2164.8	8.0 л/с /гүний худаг/	3700	8009.76
2	Үйлдвэрлэлд зарцуулагдах ус, тн/хоног	253.58	68 466.6	253.58 м ³ /хоног	3700	253326.42
	Нийт дүн	260.14	70631.1			261336.180

1.4.2. Үйлдвэрийн цахилгаан хангамж

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийг Батноровын дэд станцаас 35кВ-ын шугам татан хангана. Өндөр хүчдэлийн шугамын нийт трассын урт 11 км үүнээс 0.45км нь кабель шугам байна.

Үйлдвэрлэлийн талбайд цахилгаан хэрэглэгч объектууд нь баяжуулах үйлдвэр, үйлдвэрийн оффис, үйлдвэрийн ажилчдын кемп, засвар механикийн цех, ШТС зэрэг байна. Баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангахын тулд бие биеэсээ үл хамаарах 2 хүчний трансформатор бүхий ЕБДС-ын схемийг сонгов.

1.4.3. Баяжуулах үйлдвэрийн лаборатори

Баяжуулах үйлдвэрийн дэргэд эрдсийн шинжилгээний лаборатори байна. Технологийн туршилтыг үндэслэн үйлдвэрлэлийн явцад уг лабораторит үйлдвэрлэлийн, технологийн дамжлагыг хэвийн явуулах ажиллагааг хянан зохицуулна.

Лаборатори нь анхдагч хүдрийн шинж чанарт шинжилгээ хийж хянах болон үйлдвэрийн технологийн биелэлтэнд хяналт тавьж хэвийн ажиллагааг хангах, технологийн зааврын дагуу үйлдвэрийн дамжлагуудын хэсгүүдийн үйл ажиллагааг явуулах, үйлдвэрийн технологийн дээжийг шинжлэх бүтээгдэхүүний чанарт иж бүрэн шинжилгээ судалгаа хийх зорилготой.

Лабораторит нь дээж шинжилгээнд бутлан бэлтгэх тоног төхөөрөмжүүдээс гадна аналитик жин, хатаах шүүгээ, шатаах зуух, калориметр, стандарт шигшүүр, химийн шилэн савууд зэрэг техник тоног төхөөрөмж бүрэн тоноглогдоно. Лабораторит CaF_2 , CaCO_3 , SO_2 , SO_3 , P_2O_5 , S ба бусад элементүүдийг ээлжийн лаборантууд 24 цагт шинжилгээ хийж үзүүлэлтүүдээ тодорхойлно.

Баяжуулах үйлдвэрийн химийн лабораторит флюоритын баяжмал, товарын бүтээгдэхүүн гаргаж авах технологийн процессод хяналт тавьж экспресс шинжилгээ хийх. Технологийн процессод хэрэглэх урвалын шинж чанарт хяналт тавих ажлуудыг дүрэм журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

1.4.3. Хаягдлын аж ахуй

Хаягдлын аж ахуй нь нийт 77739.6 м³ хатуу хаягдлыг агуулж байх ба ойролцоогоор 7500м² талбай эзлэх ба баяжуулах үйлдвэрийн зүүн урд хэсэгт төлөвлөсөн.

1.4.4. Дэд бүтэц, барилга байгууламж

Төслийн хугацаанд үйлдвэрлэлийн барилга байгууламжуудыг барьж ашиглах бөгөөд
эдгээр барилгууд нь зориулалтаасаа хамаарч сэндвичэн болон контейнер байгууламжууд байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул зүй. Энэхүү талбай нь нам толгодорхог, тал хээрийн бүсээс говийн төрхөд шилжих завсрын ландшафт бүхий бүсэд оршино. Судалгаа хийгдсэн хэсэг нь нам ендөрлөг уулс бүхий тал хээрийн бүсэд багтдаг. Ордын талбайн орчмоор дундаж ендөржилт нь далайн түвшнээс дээш 1150-1300 м өргөгдсөн байдаг. Уул толгодын орой мөлгөрдүү бөөрөнхий хэлбэртэй, аажим налуутай ба ордын орчим орших хамгийн өндөр уул нь Сүүл өндөр уул (1340.0м) болно.

Усан сүлжээ. Усан хангамжийн хувьд байнгын урсгал ус байхгүй зөвхөн түр зуурын ус урсдаг, хуурай сайруудтай. Томоохон хотгор бүтцүүдийг дагасан давс, хужиртай, том жижиг нуур, тойром элбэгтэй. Гадаргуугийн ус ховор бөгөөд цөөн булаг шанд нь тухайн жилийн хур тунадаснаас хамаарч ундарга нь хэлбэлзэх ба гантай жил ширгэдэг байна. Ундны усны хэрэгцээг гол төлөв гар худгуудаас хангана.

Уур амьсгал. Эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай говийн бүсэд хамаарах ба салхины гол чиглэл баруун хойноос зүүн урагш, дундаж хурд 5-10 м/сек, хавар, намрын хуурайшилттай үед заримдаа 20-30 м/сек хүрдэг байна. Улаанбаатар хотын цаг уурын станцын мэдээгээр жилийн дундаж температур - 4°, өвөл хамгийн хүйтэн 12 сард -32.5°, зун хамгийн халуун 7 сард +30° хүрэх ба жилд унах хур тунадасны хэмжээ 80.5 мм. Зуны улиралд хур тунадас харьцангуй элбэг, хавар намрын улиралд хуурайдуу байдаг. Цасан бүрхүүлд эрт хучигдах ба томоохон хөндийнүүдэд цасны зузаан 1.0 м-ээс давдаг байна.

Ан амьтан, ургамал. Энэ нутагт хиаг -хялганат, хялгана-хиагт хээрийн ургамлын бүлгэлгэмдэл зонхилох ба говь-хээрийн бүсийн бор шороон хөрстэй. Амьтдаас үнэг, хярс, могой, хар сүүлт, цагаан зээр, тарвага, жижиг мэрэгчид, төрөл бүрийн шувууд бий.

Дэд бүтэц. Дэд бүтцийн хувьд орд нь сайн хөгжсөн бүсэд оршдог. Баянжаргалан сумын төв нь төвийн эрчим хүчний системд холбогдсон ба ШТС болон эмнэлэг, худалдаа үйлчилгээний газруудтай тул хүнс, ахуйн зүйлсийг орон нутгаас хангах боломжтой.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тухай ерөнхий удирдамж

“Шашир-Оргил” ХХК-ийн “Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.2 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 4. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	х				х		х	х		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтоцын өөрчлөлт	х				х		х		х	
Зэрлэг амьтдын орон зай		х			х		х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х			х					х
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		х			х		х			х
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х		х	х		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	х				х		х	х		
Хөрсний эвдрэл, бохирдол	х				х		х		х	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х		х		х	

Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x		x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх								
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх								
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх								
5. Эдийн засаг, нийгмийн асуудал								
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x		x		x			x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x		x		x		x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x		x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x		x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x		x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x		x		x			x
6. Бусад нөлөөлөл								
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x		x		x			x
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x		x				x	
Хүчтэй салхи, уруйн үер								
Дүн	17	3	1	19	19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд үйлдвэрийн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо *магадлан жагсаах* аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 5. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	x			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	x			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	x			
2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				x
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			x	
Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				x
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	x			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		x		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		x		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				x
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x	
4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			x	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			x	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				x

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

Хүснэгт 6. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа болон хаягдлын сангаас үүсэх тоосжилтын нөлөөгөөр хөрс, ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлнэ.
2	Агаар	Хайлуур жоншийг ачих, тээвэрлэх, хаягдлын сангаас үүсэх тоос зэргээс агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Баяжуулах үйлдвэр орчимд тоосжилт үүсэх	Баяжуулах үйлдвэр орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Баяжуулах үйлдвэр болон тээврийн зам	км	25.0	1.6	40.0 x 25 удаа = 1 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Үйлдвэр орчим, тээврийн гол зам дагуу	ОХШХ-ийн зардлаас				Жилд 2 удаа	
	Хаягдлын сангаас ууршилт явагдах	Ууршилт явагдах процессыг багасгахын тулд хаягдлын санд хөвөгч бөмбөг ашиглан бүрхүүл үүсгэх	Хаягдлын сан	ширхэг	5000.0	1	5000.0	Үйл ажиллагааны турш	
	Тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны явцад агаар орчинд хорт хийн ялгарал үүснэ.	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд оношлогоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийж, түлшний зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Тоног төхөөрөмж, автомашин	ширхэг	1000.0	1	1000.0	Авто машины тээвэр хийх үед	
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс үйлдвэр, бусад байгууламжуудын дор	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Овоолго	Үйл ажиллагааны зардлаас				Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль

	дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго			MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
2	Үйлдвэрийн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Хүнд машин механизм явах зам	Үйл ажиллагааны зардлаас	Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай МУ-ын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
Ургамлан нөмрөг						
1	Уурхайгаас ирсэн жоншийг ялгах, хүдэр буулгах талбай, хаягдлын сангаас үүсэх тоосжилт зэргээс ургамлан нөмрөгт сөрөг нөлөө үзүүлнэ.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай	Ашиглалтын зардлаар	Ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны туршид тоосжилт үүсэх, энэ нь ойролцоох газрын ургамлын фотосинтезийн үйл ажиллагаанд нөлөөлөн ургалтын эрчмийг доройтуулах	Тоосжилтоос үүсэх дам нөлөөг багасгах үүднээс шаардлагагүй замуудыг хаах, усалгаа хийх, байнгын хяналт тавьж байх	Төслийн нөлөөллийн бүс	Мониторингийн зардлаар		
2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн				7 000.0		

4.2. Үйлдвэрийн орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Үйлдвэрийн талбайн 10 хувьд ногоон байгууламжийг бий болгох шаардлагатай ба үйлдвэрийн орчинд хамгийн их тоос шороо дэгдэх эх үүсвэр болох хаягдлын далан дагуу байгуулах хэрэгтэй.

Хүснэгт 8. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тоосжилтийг бууруулж, ногоон байгууламжийн ургалтыг нэмэгдүүлэх	Нэг наст болон олон наст ургамал тарилтанд бэлтгэх, хашаалах	Үйлдвэрийн талбайн сонгосон газарт ногоон байгууламж хийх	100	20.0	2 000.0	10-р сард	MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд MNS 5917:2008 “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах” стандарт
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн	Жил бүр мод тарих	Үйлдвэрийн талбайд	300 ш	10.0	3000.0	10-р сард	
	Нийт					5 000.0		

4.3. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө*Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2025 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.4.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*Хүснэгт 10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Үйлдвэр орчимд археологийн дурсгал илрээгүй болно.						
2	Палеонтологийн дурсгал	Үйлдвэр орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.						

4.5.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Үйлдвэр	1	Үйл ажиллагааны зардлаас		2025 онд	
2	Ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт	Үйлдвэрийн ажилчид	1	1000.0	1000.0	2025 онд	-
		семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах						
		Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангах менежментийн зардал	Үйлдвэрийн ажилчид	1	1000.0	1000,0		
3	Хаягдлын сангаас ан амьтан, шувуу ундаалахгүй	Хаягдлын сангаас ан амьтан, шувуу ундаалахгүй байлгахын тулд шувуу үргэх төхөөрөмж суурилуулах болон технологийн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх, түүнчлэн хаягдлын далан сэтрэх, хаягдлын сангаас ус шүүрч буй эсэхэд байнгын хяналт тавьж ажиллах	Хаягдлын сан орчим	4	Үйл ажиллагааны зардал			
4	Химийн бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажлыг гүйцэтгүүлэх	Химийн бодисын хог хаягдал	Ашиглалтын зардлаас		Үйл ажиллагааны турш	-	
		Аюултай хог хаягдлын тоо бүртгэлийг тогтмол хийх						
		Химийн бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох						
	Нийт					2000.0		

4.6.Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө


№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Үйлдвэр орчим	ш	200.0	1	200.0	2025 онд	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Үйлдвэр орчим	сар	80.0	10	800.0	2025 онд	
2	Аюултай	Химийн бодисын сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгөх	Үйлдвэр орчим	Үйл ажиллагааны зардлаар				2025 онд	
3		Ангилан ялгаж эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэн өгөх	Үйлдвэр орчим	Үйл ажиллагааны зардлаар				2025 онд	
Нийт				1000.0					

4.7.Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар				
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Хаягдлын сан, тээврийн гол зам, тосгон орчим 3 цэгт	Жилд 4 удаа, улирал бүр	4000.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлаас	MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Дуу шуугиан				
Дуу шуугиан, чичиргээ	Үйлдвэрийн талбай, тоног төхөөрөмж, ажлын байранд 3 цэгт	Жилд 4 удаа, хавар, намар	1000.0	MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
	Авто тээврийн зам дагуу	Жилд 4 удаа, хавар, намар		MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний нефть бүтээгдэхүүний бохирдол	Тээврийн гол зам, тосгон орчим 2 цэгт	Жилд 4 удаа, улирал бүр	1000.0	MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. MNS 3297:1991 Хот суурин газрын хөрсний ариун Ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин				
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны эрүүл ахуйн шинжилгээ	Баяжуулах үйлдвэрийн худгууд	Жилд 4 удаа, улирал бүр	2000.0	MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Төслийг хэрэгжүүлэх эхний жилийн зардлын урьдчилсан дүн			10000.0	



Зураг 3. ОХШХ-ийн дээж авах цэгүүд

4.8. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			4-5-р сар	6-8-р сар	9-10-р сар		
1	Үйлдвэрийн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Үйлдвэрийн дарга	
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн	
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Үйлдвэрийн дарга	

4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 15. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Хэнтий аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	2000.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Төслийн нөлөөллийн бүсийн иргэд, сумын иргэд	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	
3		Хэнтий аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Үйлдвэрийн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 27.0 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 7.0 сая төгрөг, Ногоон байгууламж байгуулах, Тэрбум модын хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд 5.0 сая.төг, осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд 2 сая.төг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 1 сая.төг, ОХШХ-т 10 сая төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 2 сая.төг зарцуулахаар тооцсон болно.